


Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны
яамны 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн
02/30 дугаар албан бичгийн хавсралт



ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
САЛБАРЫН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ
(2024 оны жилийн эцсийн байдлаар)

2025.02.05

Улаанбаатар хот

Д/д	Үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин /2024/	Хүрсэн түвшин	Биелэлт	Тайлбар	Үнэлгээ
1	Цахим засаглалын хөгжлийн индекс	74 /2022/	-	46	Нэгдсэн Үндэстний байгууллага "Цахим засаглалын хөгжлийн индекс"-ийг 2 жил тутамд шинэчлэн гаргадаг. Монгол Улсын хувьд 2020 онд 193 орноос 92 дугаар байранд байсан бол 2022 онд 18 байраар урагшилж 74 дүгээр байранд орсон. 2024 оны цахим засаглалын хөгжлийн индексээр дэлхийн 193 орноос даруй 28-н байр ахиж, 2024 оны 09 дүгээр сарын 17-ны өдөр 46 дугаар байранд эрэмбэлэгдсэн.	2 жилд 1 удаа	100
2	Цахим оролцооны индекс	57 /2022/	-	37	E-Participation (2024 EPART: 0.7808) буюу Цахим оролцооны индекс 37-д эрэмбэлэгдэж ХУРДАН, И-Монголиа үйлчилгээний цахимжилтийн үр дүн өндрөөр үнэлэгдсэн байна.	2 жилд 1 удаа	100
3	Мэдээлэл, харилцааны холбооны хөгжлийн индекс	85.9 /2023/	-	87	Олон Улсын Цахилгаан Холбооны Байгууллагаас гаргадаг Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн хөгжлийн индексээр Монгол Улс 2023 онд 85.9 байсан бол 2024 онд 87 болж урагшилсан.	Жил бүр	100
4	Дэлхийн инновацын индекс	68	-	67	Дэлхийн оюуны өмчийн байгууллагаас жил бүр гаргадаг улс орнуудын инновацын чадавх, амжилтаар нь эрэмбэлдэг "Дэлхийн инновацын индекс"-ээр 2024 онд 133 орноос 6 дугаар байр эзэлж, өмнөх оноос 1 байр урагшилсан.	Жил бүр	100
5	Олон Улсын Кибер аюулгүй байдлын индекс	56.36	-	56.36	Тайлант хугацаанд Олон Улсын Цахилгаан Холбооны Байгууллагаас кибер аюулгүй байдлын индекс тодорхойлох судалгаа хийгдээгүй. Кибер аюулгүй индексийг тодорхойлох шалгуур үзүүлэлтүүдийг хангахад чухал ач холбогдол бүхий "Кибер аюулгүй байдлын үндэсний стратеги"-ийг Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 493 дугаар тогтоолоор батлуулж, тус яамнаас хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Стратегийн 1 дүгээр зорилтын хүрээнд Үндэсний хэмжээний кибер халдлагаас хамгаалах төлөвлөгөөг Засгийн газрын 2024 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн тогтоолоор батлуулсан. Мөн	3 жилд 1 удаа	70

					кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх журмыг батлуулж, хуулийн этгээдийн хүсэлтэд үндэслэн эрсдэлийн үнэлгээ хийх зөвшөөрлийг олгож байна. Стратегийн 2 дугаар зорилтын хүрээнд онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагуудад кибер аюулгүй байдлын дотоод журам боловсруулах сургалт зохион байгуулж, хүний нөөцийг чадавхжуулсан. Стратегийн 3 дугаар зорилтын хүрээнд бүх нийтийн кибер аюулгүй байдлын мэдлэг олгох 15 контентыг нийгмийн сүлжээгээр түгээсэн. ШУТИС, МУИС, Удирдлагын академийн 24 багшийг кибер аюулгүй байдлын мэргэшүүлэх сургалтад хамруулсан. Кибер дадлага, сургуулилтыг 2024 оны 01 дүгээр сарын 12-13-ны өдрүүд, 12 дугаар сарын 12-13-ны өдрүүдэд тус тус зохион байгуулж, 80 гаруй албан хаагчийг хамруулсан. Стратегийн 4 дүгээр зорилтын хүрээнд Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх Нийтийн төв УТҮГ-ыг 2024 оны 06 дугаар сарын 14-ний өдөр Олон Улсын Кибер Аюулгүй Байдлын Байгууллага "FIRST"-д гишүүнээр элсэхэд дэмжлэг үзүүлсэн. Гадаад хамтын ажиллагааны хүрээнд АНУ-ын MITRE байгууллага, Японд төвтэй Trend Micro компанитай хамтран кибер аюулгүй байдлын 2 удаагийн сургалтыг зохион байгуулсан. Стратегийн 5 дугаар зорилтын хүрээнд Монгол Улсын кибер аюулгүй байдлын өнөөгийн түвшинг тодорхойлох судалгааг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага (ЖАЙКА)-тай хамтран хэрэгжүүлж буй кибер аюулгүй байдлын хүний нөөцийг хөгжүүлэх техникийн хамтын ажиллагааны төслийн хүрээнд Английн Оксфордын их сургуулийн Кибер аюулгүй байдлын чадавхын төвтэй хамтран 2024 оны 10 дугаар сарын 02-04-ний өдрүүдэд зохион байгуулсан. Төрийн болон хувийн хэвшлийн 80 гаруй байгууллагын 110 орчим ажилтан, албан хаагчид оролцсон. Хуваарийн дагуу 2025 оны 02 дугаар сард эцсийн тайлан гарна.		
6	Засгийн газрын хиймэл оюуны бэлэн байдлын индекс	109	-	98	Хиймэл оюун ухааны бэлэн байдлын индекс нь улс орнуудын хиймэл оюун ухааныг хөгжүүлэх, хэрэгжүүлэхэд бэлэн байдлыг үнэлэх зорилгоор Оксфорд Инсайт байгууллагаас жил бүр гаргадаг "Хиймэл оюун ухааны бэлэн байдлын индекс"-ээр манай улс 2024 онд нийт 188 орноос 98 дугаар байранд эрэмбэлэгдэж, өмнөх оноос 11 байр урагшилсан.	Жил бүр	100
7	Цахим аймаг төсөлд хамрагдсан аймгийн тоо	0	2	2	1."Аймаг орон нутгийн цахим шилжилтийг эрчимжүүлэх, иргэн, аж ахуй нэгжид чиглэсэн нэгдсэн систем нэвтрүүлэх 3 багц (Дархан-Уул аймагт цахим шилжилтийг эрчимжүүлэх, иргэн аж ахуйн нэгжид чиглэсэн нэгдсэн систем нэвтрүүлэх", "Өвөрхангай аймагт цахим шилжилтийг эрчимжүүлэх, иргэн,	-	100

					аж ахуйн нэгжид чиглэсэн нэгдсэн систем нэвтрүүлэх", "Дархан-Уул, Өвөрхангай аймгийн цахим шилжилтийг эрчимжүүлэх, иргэн, аж ахуйн нэгжид чиглэсэн нэгдсэн систем нэвтрүүлэхэд шаардагдах тоног төхөөрөмж суурилуулах")-ыг тендерийг 2024 оны 02 дугаар сард зохион байгуулж, гүйцэтгэчийг шалгаруулж, гэрээ байгуулан гүйцэтгэлийг хүлээн авч, хэрэгжилтэд хяналт тавин зөвлөмж өгсөн. 2.Дархан-Уул аймагт хэрэгжүүлж байгаа "Жишиг цахим аймаг" арга хэмжээний хэрэгжилттэй танилцаж, цаашид авах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулсан. 3."Цахим аймаг" бодлогын зөвлөмжийг орон нутагт хэрэгжүүлэхэд бодлогын дэмжлэг үзүүлэх зорилго бүхий ажлын хэсгийг Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2024 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн А/22 дугаартай тушаалаар байгуулж, 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдөр Дархан-Уул аймагт "Жишиг цахим аймаг" арга хэмжээний нээлтийг зохион байгуулсан. Дархан-Уул аймагт нээлттэй өдөрлөг 2024 оны 09 дүгээр сарын 09-ний өдөр зохион байгуулж, иргэд олон нийтэд "Жишиг цахим аймаг" төслийн хүрээнд хэрэгжсэн программ хангамж, үйл ажиллагааг таниулах үйл ажиллагааг зохион байгуулсан. 4.Гүйцэтгэлд үнэлгээ хийх, байнгын ашиглалтад оруулах, тасралтгүй хэвийн ажиллагааг ханган ажиллахад арга зүйн дэмжлэг үзүүлэхээр Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны А/81 дүгээр тушаалаар Дархан-Уул аймагт 2024 оны 09 дүгээр сарын 06-09, Өвөрхангай аймагт 2024 оны 10 дугаар сарын 22-ны өдөр ажиллаж, гүйцэтгэлийг шалган мэргэжил арга зүй, зөвлөмж өгч ажиллалаа.		
8	Сургалтад хамрагдсан мэргэжилтний тоо	0	350	350	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам Google компани хамтран "Grow with Google Mongolia" хөтөлбөрийг хэрэгжүүлж, 2024 онд нийт 350 мэргэжилтнийг бэлтгэсэн. Microsoft компанийн сертификаттай 1,000 мэргэжилтнийг улсын хэмжээнд бэлтгэх ажлыг 2025 онд эхлүүлэх бэлтгэл ажил хийгдэж байна.	-	100
9	Дэлхийн гарааны бизнесийн экосистемийн индекс	79	-	81	СтартапБлинк байгууллагаас жил бүр боловсруулан гаргадаг Дэлхийн гарааны бизнесийн экосистемийн индексээр 2024 онд Монгол Улс 81 дүгээр байранд орж, шилдэг 100 улсын тоонд багтаж байгаа хэдий ч өмнөх онтой харьцуулахад 2 байраар ухарсан.	Жил бүр	100